



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны гудамж 136, Утас: 7012-8801,
Факс: (976) 32-06-33, E-mail: admin@hdc.gov.mn,
<http://www.chd.moh.mn>

2015. 11. 25 № 1233
танай _____ -ны № _____ -т

Зөвлөмжийн биелэлтийн тухай

Тус төвийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитаас өгсөн 4 зөвлөмжийн биелэлтийг хүргүүлж байна.

1. Мөнгөн хөрөнгөнд тавих дотоод хяналттай холбоотой дараах ажлуудыг хийлээ.
 - Сар бүрийн эцэст касс дах бэлэн мөнгөний үлдэгдлийг баримттай нь тулган, тоолж, бэлэн мөнгөний тооллогын маягтаар баталгаажуулж байна.
 - Няравын өрөөнд хяналтын камер суурилуулан, бэлэн мөнгөний хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.
2. Гадаад дотоодын сургалтын зардлын төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, төлөвлөсөн сургалтыг тогтоосон хугацаанд нь хийхтэй холбоотой дараах ажлуудыг хийж байна.
 - Сургалтын төлөвлөгөөг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газраас авсан захиалга болон сүүлийн 5 жилд бэлтгэгдсэн хүний нөөцийн судалгаанд үндэслэн төлөвлөсөн.
 - Төгсөлтийн дараах сургалт эрхлэх зөвшөөрөлтэй Сургалт эрхлэгч байгууллагуудын сургалтын үйл ажиллагаанд Төвийн захирлын “Хяналт үнэлгээ хийх тухай” А/124 дүгээр тушаалын дагуу хяналт-үнэлгээ хийж байна.
 - 2015 оны “Хяналтын тоо, сургалтын зардал батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 141 дүгээр тушаалын дагуу төлөвлөсөн сургалтыг тогтоосон хугацаанд явуулж байна.
3. Ашиглалтын хугацаа нь дуусч ашиглах боломжгүй хөрөнгийг актлах, санал боловсуулж, түргэн тусламжийн автомашиныг шаардлагатай газарт нь шилжүүлэх, оронд нь өөрт шаардлагатай зориулалтын автомашин авах саналыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх талаар доорх ажлуудыг хийсэн. Үүнд:
 - Ашиглалтын хугацаа нь дуусаж ашиглах боломжгүй хөрөнгүүдийг актлах санал боловсруулан, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хуралд танилцуулан шийдвэрлэв.
 - Төрийн өмчийн хорооны 2015 оны 01 сарын 28-ны өдрийн 45 дугаар тогтоолын дагуу тус төвд ашиглах боломжгүй 1030 УНЭ улсын дугаартай

Volkswagen түргэн тусламжийн автомашиныг Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвд хүлээлгэн өгсөн.

- Тус төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн дагуу хөдөө орон нутаг ажлын байрны сургалт, зөвшөөрлийн шалгалтыг зохион байгуулдаг тул хөдөө орон нутгийн замд туулах чадвар сайтай автомашин авах саналаа Эрүүл мэнд, спортын яаманд 2015 оны 03 сарын 25-ны өдрийн 257 дугаар тоотгоор хүргүүлсэн.

4. Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын дагуу төсвийн орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах талаар дараах арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд:

- Төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах үүрэгтэй харуул хамгаалалт, цахилгааны засвар, мужаан зэрэг үйлчилгээг Харуул хамгаалалт эрхлэх 081 дугаартай “Эм Би Би Би Ти” ХХК-ийн “Харцага” Гэрээт харуул хамгаалалтын албатай 2015 оны 04 сарын 1-ний өдрөөс эхлэн гэрээ байгуулан ажиллаж байна.
- Байгууллагын орлогч даргын орон тоог 2015 оны 01 сарын 1-ний өдрөөс цомхотгов.
- 2015 оны төсвийн тухай хуулиар үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого нийт 234.864.000 төгрөг батлагдсан ба 2015 оны 10 сарын байдлаар үндсэн үйл ажиллагааны орлого 116.243.000 төгрөг орохоос 217.164.123 төгрөг орж 100.921.123 төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 75.370.000 төгрөг орохоос 85.700.518 төгрөг орж 10.330.518 төгрөгөөр тус тус төлөвлөгөө даван биелсэн байна.

Хувийг ЭМСЯ-ны Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, Дотоод аудитын газарт

ЗАХИРАЛ



М. БАТ-ЭРДЭНЭ